



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2015 оны 07 сарын 27 өдөр

Дугаар 5/14

Хужирт

Төлөвлөгөө батлах тухай

Монгол улсын Санхүү, эдийн засгийн сайдын 2003 оны 93 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөг боловсруулах заавар, төлөвлөгөөний үлгэрчилсэн загвар”-ыг үндэслэн ТУШААХ нь:


1. Монгол улсын Төрийн албаны шинэчлэлийн үзэл баримтлал, сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөг боловсронгуй болгон сайжруулах үүднээс холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн 2015-2017 оны үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2. Тамгын газрын үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөний бүтэц, мөн чанар, агуулга, ач холбогдлын талаар ажилтнуудад 12 дугаар сард багтаан дэлгэрэнгүй мэдээлэл өгсүгэй.

3. Төлөвлөгөөнд тусгагдсан дунд хугацааны зорилго, тухайн жилийн зорилт, хүрэх үр дүнг хангахуйц бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг тогтвортой мөрдөж, сумын хөгжлийг хангах болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтыг биелүүлэх, түүнд хувь нэмэр оруулахад төрийн албан хаагчдын мэдлэг, чадвар, хариуцлага, санаачлагыг өрнүүлж ажиллахыг Тамгын газрын албан хаагч нарт даалгасугай.

4. Засаг даргын Тамгын газрын албан хаагч бүр энэхүү төлөвлөгөөний дагуу тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэн боловсруулан батлуулж, мөрдөн ажилласугай.


ДАРГА



Д.ЭНХТҮВШИН

22000028

Өвөрхангай аймгийн Хужирт сумын  
ЗДТГ-ын даргын 2015 оны 07 дугаар сарын  
27-ны өдрийн 9/17 тушаалаар батлав



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХУЖИРТ ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

### 1.ӨМНӨХ ҮГ

“Төсвийн тухай Монгол улсын хуулийг хэрэгжүүлэх үүднээс энэхүү үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөг боловсруулж Төсвийн ерөнхийлөн захирагчтай төсвийн шууд захирагчаас байгуулсан үр дүнгийн гэрээг үндэс болгон хүргүүлж байна.

Төлөвлөгөөнд стратегийн зорилтыг тодорхойлохдоо Засаг дарга болон ЗДТГ-ын түвшинд, бүтээгдэхүүнийг байгууллагын төвшинд авч үзсэн. ЗДТГ-ын ихэнхи албан хаагчид нь гадна хэрэглэгчийн хэрэгцээг шууд хангахад чиглэгдсэн байдаг тул байгууллагаас нийлүүлэх бүтээгдэхүүнд оруулах төрийн албан хаагчийн хувь нэмэр, үр дүн, үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлт, гүйцэтгэх үйл ажиллагааг байгууллагын үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөнд бус, харин жилийн төлөвлөгөөнд дэлгэрэнгүй байдлаар тодорхойлох нь илүү зохимжтой байх боловч энэхүү хэтийн төлөвлөгөөнд тухайн ажлын байрнаас гүйцэтгэх ажил үйлчилгээг нэлээд тодорхой байдлаар тусгалаа. ҮАХТ нь байгууллагын дунд хугацаанд хүрэх үр дүнг хангахад чиглэгдсэн бодлогын баримт бичиг тул түүний үнэт чанар нь төрийн албан хаагчдын өдөр тутмын ажилд шууд мэдрэгдэхээсээ илүү зөв бодлого, хандлага чиглэл, стандарт сэтгэлгээ, удирдлага, зохион байгуулалт, арга барил, үр чадвар, соёл, үр дүн бий болгоход оршино. тэгвэл байгууллага, түүний албан хаагчдад шууд мэдрэгдэх тодорхой үр дүнг яаж бий болгох вэ? Энэ асуултын хариу нь өөрөө байгууллага, түүний албан хаагчдаас дараах зүйлийг хэрэгжүүлэхийг, ингэхдээ тодорхой мэдлэгийн үүднээс хандах, итгэл үнэмшил бий болгосон байхыг шаардах болно. Үүнд:

1. Байгууллагын удирдлага, ажилтан, албан тушаалтан бүр өнөөгийн захиргааны шинэчлэлийн үзэл баримтлал мөн чанарыг ойлгох түүнд суралцах замаар энэхүү төлөвлөгөөг хэрэгжүүлэх мэдлэг чадвар бий болгох
2. ЗДТГ албан хаагч бүр энэхүү хэтийн төлөвлөгөөний дагуу тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, мөрдөн ажиллах шаардлагатай. Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахад баримтлах гол зарчим нь түүнийг хэтийн төлөвлөгөөтэй нягт уялдуулах явдал юм. Тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажил үйлчилгээний үр дүнг тооцох шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлох үүнд тухайн албан хаагч, түүний шууд харъяалах албан тушаалтан бүр анхаарлаа төвлөрүүлэх, мэргэшлийн мэдлэг, үр чадвар эзэмшсэн байдал тань энд илүү үүрэг рольтой байх болно.
3. Энэхүү үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө үүнтэй нягт уялдуулан боловсруулсан тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө зэргийг үндэслэн төрийн албан хаагчийн ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах шаардлагатай.

Дээр дурьдсан зүйлүүдийг шат дараалан чанартай гүйцэтгэх үүргийг ЗДТГ, түүний албан хаагчид хүлээнэ. Эцэст нь тус байгууллага нь суралцагч бүтээлч, үйлчлэгч байгууллага болон төлөвших замаар үйл ажиллагааныхаа хэтийн төлөвлөгөөг илүү үр дүнтэй ханган биелүүлэх боломжтой юм.


## НЭГ.ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН МЭДЭГДЭЛ

ЗДТГ-ын дунд хугацааны хөтөлбөр болон ирэх санхүүгийн жилд нийлүүлэх бүтээгдэхүүн, төсвийн төлөвлөгөөг боловсруулахдаа сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрөөс өөрт хамааралтай заалт бүрийг хэрэгжүүлэх байгууллагаас иргэдэд хүргэх төрийн үйлчилгээг сайжруулан, тэдний хүсэн хүлээсэн эрэлт шаардлагад тохируулан урд жилүүдийн амжилтаа бататган тодорхой үр дүнд хүргэх асуудлыг авч төлөвлөлөө. Энэхүү төлөвлөгөө нь

- ✓ Ойрын 3 жилд худалдан авах /нийлүүлэх бүтээгдэхүүн/ ажил үйлчилгээ/ болон өмчлөлийн стратегийн зорилт
- ✓ Төсвийн жилийн хугацаанд нийлүүлэх бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ, чанар тэдгээрийн өртөг
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу жилийн эцсийн санхүүгийн тайлангийн ижил үзүүлэлтээр боловсруулсан төсөв буюу төсвөлсөн баланс
- ✓ Ерөнхий менежерээс байгууллагын эд хөрөнгийг хамгаалах, боловсон хүчний чадварыг бэхжүүлэх талаар авч хэрэгжүүлэх болон өмчлөгчийн эрхтэй холбогдсон бусад асуудлууд
- ✓ Төсвийн жилд гарах капитал зардал/санхүүгийн эх үүсвэртэй уялдсан/
- ✓ Тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой төсөвт орох орлого, зарлагын талаархи мэдээлэл зэргээс бүрдэнэ.

Төлөвлөгөөнд тусгагдсан дунд хугацааны зорилго, тухайн жилийн зорилт, хүрэх үр дүнг хангахаар нийлүүлж буй бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ нь сумын хөгжлийг хангах болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтыг биелүүлэх, түүнд хувь нэмэр оруулахад чиглэгдэнэ. Иймд дунд хугацаанд ЗДТГ-аас нийлүүлэх бүтээгдэхүүнийг тогтвортой мөрдөж, харин тухайн жилд нийлүүлэх бүтээгдэхүүний шалгуур үзүүлэлт бүрээр хүрэх үр дүн, өртөг түүнд шаардагдах төсвийн зардлын төлөвлөгөөг төсвийн ерөнхийлөн захирагчтай урьдчилан тохирсноор жил бүр тодотгон боловсруулж батлуулан ажиллана. Төлөвлөгөөг сумын хөгжлийн дунд хугацаанд хүрэх үр дүнг хангахад ЗДТГ-аас оруулах хувь нэмэр, үзүүлэх үйлчилгээг иж бүрэн нарийвчлан тодорхойлж, холбогдох онол, үзэл баримтлал, хууль тогтоомжид нийцүүлэн боловсрууллаа. Төлөвлөгөөний биелэлтийг жил бүр сумын Засаг дарга бөгөөд төсвийн ерөнхийлөн захирагчид тайлагнах, хүрсэн түвшинг баталгаажуулах, тогтвортой ахиулах, сул тал алдаа дутагдлыг засч залруулах, дахин давтахгүй байх, холбогдох дээд шатны байгууллагаас өгсөн даалгаврыг ханган биелүүлэх, цэцэрлэгийн үйл ажиллагаа, түүний үр дүнгийн талаар сумын иргэдэд нээлттэй мэдээлж байх болно.

ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ШУУД ЗАХИРАГЧ Д.ЭНХТҮВШИН



2015 оны 07 сарын 04-ний өдөр

## ХОЁР. СТРАТЕГИЙН ҮНДСЭН ЗОРИЛТУУД

### ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХӨГЖЛИЙН УРТ ХУГАЦААНЫ ХҮРЭХ ҮР ДҮНГ ХАНГАХ ТОГТОЛЦОО.

#### 2.1. Алсын хараа

Тамгын газрын боловсон хүчний төрийн албаны мэдлэг боловсролыг дээшлүүлэн мэргэшсэн чадварлаг, тогтвортой төрийн албанд сэтгэлээ өгсөн хамт олныг бүрдүүлснээр иргэддээ орон нутагтаа ажиллаж амьдрах таатай орчныг бүрдүүлэх алсын хараатай амьдрана.

#### 2.2. Эрхэм зорилго, эрхэмлэх үндсэн зарчим

Нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулан иргэддээ хөнгөн шуурхай, ил тод шудрагаар үйлчилж, сумынхаа нийгэм, эдийн засгийн хөгжлийг хангахад оршино.

Сумын хөгжлийн эрхэм зорилго нь байгууллагын урт хугацааны хүрэх үр дүнгийн цогц илэрхийлэл юм. Иймд энэхүү эрхэм зорилгыг хангахын тулд тус байгууллагад ажиллаж буй хувь хүн, хамт олон тус бүр хувь нэмэр оруулах ёстой. Үүний тулд байгууллага хамт олон нь дунд хугацааг баримжаалсан удирдлагыг хэрэгжүүлэх шаардлага гарч байна. Байгууллагын хөгжлийг хангах энэхүү тогтолцоог сумын ИТХ, Засаг дарга, төсвийн шууд захирагч нар нэгдсэн удирдлагаар хангаж ажиллана.


Энэхүү эрхэм зорилгыг хангаж ажиллахын тулд дараах эрхэм зарчмуудыг үйл ажиллагаандаа эрхэмлэнэ.

- ✓ Хууль эрх зүйн, төрийн албаны /захиргааны/ өндөр мэдлэгтэй төрийн албан хаагчдаар байгууллагын хамт олныг бүрдүүлж үүрэг хариуцлагаа бүрэн ухамсарлан ажиллах
- ✓ Төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомжийг чанд сахин, багшийн ёс зүйг эрхэмлэн чин үнэнч, шудрага, аливаа үзэл суртлаас ангид байх зарчмыг баримталж ажиллах
- ✓ Иргэдэд үйлчлэх үйлчилгээндээ хөнгөн шуурхай, соёлтой байдлыг нэвтрүүлэн, үнэн бодитой, алдаа мадаггүй, цаг үеэ олсон, ашиг тустай байдлыг хангаж ажиллана.

#### Үйл ажиллагааны хамрах хүрээ

ЗДТГ-ын үйл ажиллагааны хамрах хүрээг дор дурьдсанаар сонгож байна.

## ЗДТГ-ын үйл ажиллагааны стратегийн загвар.



## 2.4 Стратегийн зорилт / хүрэх үр дүн/

### Стратегийн зорилт:

ЗДТГ нь Эрхэм зорилгынхоо хүрээнд доор дурьдсан үйл ажиллагааны стратегийн зорилтуудыг хэрэгжүүлнэ. Үүнд:

### Стратегийн зорилт 1.

Нутгийн өөрөө удирдах байгууллага, нутгийн захиргааны байгууллагын ажлын уялдааг сайжруулж, орон нутагт хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг шуурхай зохицуулалтаар ханган, иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх

### 2.Стратегийн зорилт 2

Аймаг сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг шуурхай, зохицуулалтаар хангах

### 3.Стратегийн зорилт 3

Засаг даргын тамгын газрыг хөгжүүлж, иргэдэд мэргэшсэн тогвортой, чадварлаг төрийн албаар үйлчлэх бүтэц тогтолцоог бүрдүүлэх

### 4.Стратегийн зорилт 4

Нутаг дэвсгэртээ Эдийн засаг, байгаль орчин, нийгмийн хөгжлийг хангах үйл ажиллагааг зохицуулалт зохион байгуулалтаар хангах

## 2.3.Орчны шинжилгээ

### Дотоод орчинд

Чиглэл	Давуу тал	Сул тал
Удирдлага зохион байгуулалт	-Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хуулиар хэрэгжиж буй үр дүнд чиглэсэн бүтээгдэхүүнийг нийлүүлэх чадварлаг боловсон хүчнээр боломжийн хэмжээнд хангагдсан -Тамгын газрын ажиллагсад олон жилийн судалгаанд тулгуурлан ирээдүйгээ харсан үйл ажиллагаа явуулдаг -Иргэдийн эрэлт хүсэлтийг хүлээн авч дүгнэлт хийх чадвартай -Ажилтнуудын өрөө тасалгаа, зарим техник хэрэгслээр хангагдсан -Ажлын байрны тодорхойлолттой, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан мөрдөж биелэлтэнд нь хяналт тавьдаг.	-Төсвийн тухай хуулийн талаар бүрэн гүйцэд мэдлэгтэй болж чадаагүй -Төрийн хууль тогтоомж гаргасан шийдвэр, зохиож байгаа ажил хүн бүрт хүрдэггүй, биелэлтийг хянах дүгнэх ажил хангалтгүй -Ажлаа нийтэд мэдээлэх суртчилах ажил хангалтгүй -Ажилтнуудын ажил гүйцэтгэх чадвар бүтээлч санаачлага жигд биш -Тамгын газрын ажилтнуудын дотоод сүлжээ ашиглалт муу -
Эдийн засаг санхүүгийн нөхцөл байдал	-Сумын ЗДТГ-ын болон сумын ажлын амжилтаараа аймагтаа сүүлийн 5 жилд эхний байранд орж ажиллаж байгаа -Нутаг дэвсгэрийн байдал дэд бүтцийн хувьд /аймагт ойрхон улсын	-Мал аж ахуйг байгалийн бэрхшээлээс хамгаалах тэжээл бэлтгэх талбай билчээр хомс бөгөөд үер ган болоход эрсдэлд орох магадлал их

	төв засмал замд харьцангуй ойрхон -Аялал жуулчлалын маршрутын төд байх боломж их -Рашаан ус болон шавран эмчилгээний улсын хэмжээний үйлчилгээтэй	-Ажил үүргээ явуулах санхүүгийн нөхцөл хангалтгүй -Орлого нэмэгдүүлэх шинэ эх үүсвэр хангалттай бус -Жижиг дунд үйлдвэрлэл сул хөгжсөн.
--	---	---

### Гадаад орчинд

Чиглэл	Давуу тал	Сул тал
Улс төрийн хүчин зүйл	УЛс төр нийгэм эдийн засгийн тогтвортой байдал бий болсон	Зарим тохиолдолд улс төржих хандлага гарч болзошгүй
Нийгмийн салбарын хүрээнд	-Төрийн үйлчилгээний байгууллага болох сургуулийн сургалтын орчин бүрдүүлэх талаар бусад сумдаас харьцангуй боломжийн -10 жилийн сургууль компьютерийн кабинеттэй, бүсийн төв сургууль болсон -Хүн эмнэлгийн ажил тогтворжиж эхэд ээлтэй эмнэлгийн болзол хангасан -Соёлын төвийн үйл ажиллагаа улс аймагт дээгүүр үнэлэгдэж байгаа Цэцэрлэг яслийн сургууль хүмүүжлийн ажил хэвийн явагдаж СӨБ олгох талаар үр дүнд хүрсэн	-Хүн эмнэлгийн байр хүн амын өсөлтөөс үлэмж хоцорсон оншилгооны ойр зуурын багаж, урвалж байхгүйгээс хамгийн наад талын шинжилгээ хийж чадахгүй байгаа
Байгаль орчны хүрээнд	-Ой тал хээр хосолсон бог мал ялангуяа хонин сүрэг өсгөхөд таатай нөхцөлтэй	-Шаварлага хатуу хөрстэй тул газар тариалан эрхлэх боломж муутай -Бэлчээрийн талхалдалд орсон нилээд газартай -Ургамлын бүрхэвч алдагдаж элсний нүүдэлд өртөмтгий болсон

### 3,4 Стратегийн зорилт /хүрэх үр дүн/

#### Стратегийн зорилт:

Сумын Засаг даргын тамгын газар нь Эрхэм зорилгынхоо хүрээнд доор дурьдсан үйл ажиллагааны стратегийн зорилтуудыг хэрэгжүүлнэ. Үүнд:

#### Стратегийн зорилт 1.

Нутгийн өөрөө удирдах байгууллага, нутгийн захиргааны байгууллагын ажлын уялдааг сайжруулж, орон нутагт хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг шуурхай зохицуулалтаар ханган, иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх

#### 2.Стратегийн зорилт 2

Аймаг сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг

шуурхай, зохицуулалтаар хангах

### 3.Стратегийн зорилт 3

Засаг даргын тамгын газрыг хөгжүүлж, иргэдэд мэргэшсэн тогвортой, чадварлаг төрийн албаар үйлчлэх бүтэц тогтолцоог бүрдүүлэх


### 4.Стратегийн зорилт 4

Нутаг дэвсгэртээ Эдийн засаг, байгаль орчин, нийгмийн хөгжлийг хангах үйл ажиллагааг зохицуулалт зохион байгуулалтаар хангах

### 3.5.Үйл ажиллагааны хамрах хүрээ

Сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны хамрах хүрээг дор дурьдсанаар сонгож байна.


### Засаг дарга,түүний Тамгын бүтцийн загвар.





Сумын ЗДТГ-ын үйл ажиллагааны стратегийн бүтцийн загвар нь шаардлагатай албан тушаал/ажлын байр/-ын хэрэгцээг тодорхойлох үндэслэл болно. Сонгон авсан үйл ажиллагааны бүтцийн загварын хүрээнд үйл ажиллагааны стратегийг хэрэгжүүлэхэд шаардлагатай албан тушаал/ажлын байр/буюу орон тооны хэрэгцээг тодорхойлон гаргав.

Үйл ажиллагааны зохион байгуулалтын ерөнхий загвар



3.6. Энэ тэргүүнд худалдан авах /нийлүүлэх бүтээгдэхүүн ангиар/

Засаг даргын Тамгын газрын стратегийн зорилтыг хангахын тулд зайлшгүй нийлүүлэх бүтээгдэхүүний ангийг дор дурьдснаар тодорхойлж байна.

**Хэрэгжүүлэх арга хэмжээ 1.** Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, засаг даргаас гаргах шийдвэрийг боловсруулах үйл ажиллагааг боловсронгуй болгох  
**Хэрэгжүүлэх арга хэмжээ 2.** Нутгийн өөрөө удирдах байгууллага болон Засаг даргын шийдвэр, бусад хууль тогтоомжийг сурталчлах, биелэлтийг хангах ажлыг нутаг дэвсгэртээ шийдвэрлэх  
**Хэрэгжүүлэх арга хэмжээ 3.** Нутаг дэвсгэрийн цэрэг иргэний хамгаалалтын бодлого боловсруулах хэрэгжилтийг хангах  
**Хэрэгжүүлэх арга хэмжээ 4.** Орон нутагт тулгамдаж буй асуудлыг бүх талаас нь

- шинжлэн үзэж асуудлыг оновчтой хувилбараар шуурхай шийдвэрлэх
- Хэрэгжүүлэх арга хэмжээ 5.**Засаг дарга тамгын газраас иргэдтэй өдөр тутам харилцах харилцааг зохицуулах, зохион байгуулах
- Хэрэгжүүлэх арга хэмжээ 6.**Хуулиар зохицуулагдсан иргэний бүртгэл мэдээлэл, үйлчилгээний ажлыг зохих дүрэм журмын дагуу хэрэгжүүлж зохион байгуулах
- Хэрэгжүүлэх арга хэмжээ 7.**Сумын төрийн албыг хүний нөөцөөр тогтвортой хангахад зохицуулах зохион байгуулах
- Хэрэгжүүлэх арга хэмжээ 8.**Дотоод ажил үйлчилгээ буюу албан хэрэг хөтлөлт стандарт
- Хэрэгжүүлэх арга хэмжээ 9.**Тамгын газрын төлөвлөлт зохион байгуулалтын ажлыг боловсронгуй болгож үйл ажиллагаа үр дүнгийн нэгдлийг хангах
- Хэрэгжүүлэх арга хэмжээ 10.**Байгууллагын оновчтой бүтэц бий болгон ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтоор үүргийг тэнцвэржүүлэн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлж, мэргэшсэн чадварлаг боловсон хүчнээр, стандартад тохирсон ажиллах нөхцөлд хуулийн хүрээнд тохирсон эрх мэдэлтэй ажиллуулах
- Хэрэгжүүлэх арга хэмжээ 11.**Сумын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлийг үндэслэл сайтай боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохицуулалтаар хангах
- Хэрэгжүүлэх арга хэмжээ 12.**Татварын орлого бүрдүүлэлтэнд тавих хяналтыг боловсронгуй болгох
- Хэрэгжүүлэх арга хэмжээ 13.**Сумын төсвийн зарлага санхүүжилт зарцуулалтанд тавих хяналтын үйл ажиллагааг зохицуулалтаар хангах
- Хэрэгжүүлэх арга хэмжээ 14.**Сумын эдийн засаг, нийгэм, байгаль орчны статистик мэдээллийн чанар, үр нөлөө ашиглалтыг сайжруулах
- Хэрэгжүүлэх арга хэмжээ 15.**Нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, ашиглах нөхөн сэргээх үйл ажиллагааг зохицуулах, хуулийн биелэлтэнд хяналт тавих
- Хэрэгжүүлэх арга хэмжээ 16.**Нутаг дэвсгэртээ газар зохион байгуулалтын ажлыг хуулийн хүрээнд зохицуулах, зохион байгуулах
- Хэрэгжүүлэх арга хэмжээ 17.**Хүнс хөдөө аж ахуйн салбар дахь бодлого, зохицуулалт
- Хэрэгжүүлэх арга хэмжээ 18.**Авилгын эсрэг үйл ажиллагаа явуулах
- Хэрэгжүүлэх арга хэмжээ 19.**Нийгэм хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн бодлого зохицуулалт.
- Хэрэгжүүлэх арга хэмжээ 20.**Хүүхэд залуучуудын хөгжлийн талаар

### 3.7. Стратегийн зорилт, бүтээгдэхүүний анги хоорондын уялдаа

Стратегийн зорилт 1. Орон нутаг хууль тогтоомж тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг шуурхай зохицуулалтаар хангаж, Иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх	Хэрэгжүүлэх арга хэмжээ 1, 2, 3, 5, 6, 7, 15, 18
Стратегийн зорилт 2. Аймаг сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохицуулалтаар хангах	Хэрэгжүүлэх арга хэмжээ 7, 1, 2
Стратегийн зорилт 3. Засаг даргын Тамгын газрыг хөгжүүлж, иргэдэд мэргэшсэн тогтвортой, чадварлаг төрийн албааар үйлчлэх бүтэц	Хэрэгжүүлэх арга хэмжээ 5, 6, 9, 10, 11,